

АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 1.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд
- 1.2 Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд
- 1.3 Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд
- 1.4 Хүний нөөцийн ажлын хүрээнд
- 1.5 Сургалтын ажлын хүрээнд
- 1.6 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд
- 1.7 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд
- 1.8 Мэдээллийн технологийн чиглэлээр
- 1.9 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд

Хоёр. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 2.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.3 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.4 Улсын бүртгэлийн хяналт шалгалтын ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.5 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд
- 2.6 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд

Гурав. УИХ болон орон нутгийн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд

- 3.1 Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх
- 3.2 Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх

Дөрөв. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж хуваахтай холбоотой авсан арга хэмжээ

Тав. Ковид-19 цар тахлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Зургаа. Зохион байгуулсан бусад ажил

Долоо. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Найм. Санал /Тулгамдаж буй асуудал/

НИЙСЛЭЛ ДЭХ УЛСЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тус газраас 2020 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Захиргаа удирдлагын хэлтэс /14/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /12/, Дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтэс /411/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 441 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1.466.000 /нэг сая дөрвөн зуун жаран зургаан мянга/ гаруй иргэнд төрөөс явуулж буй улсын бүртгэлийн талаарх бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, өөрийн харьяа 187 нэгжээс Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж бусад холбогдох заавар журамд заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2 тогтоолын 12 заалт, нийт 2 шийдвэрийн 12 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 12 байгаа бөгөөд хэрэгжилт 100%-тай байна.

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны байгууллага, агентлагын дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, газар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын тогтоол 1, Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл 9, Хууль зүй дотоод хэргийн яамнаас 3 чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газраас үйл ажиллагаатай холбоотой 5 тушаал, хүний нөөцтэй холбоотой 181 тушаал, 34 чиглэл, зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 10 захирамж, 19 чиглэл, 4 зөвлөмж тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтын хэрэгжилт:

2020 онд 10 хорооноос иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг төлөвлөн нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулан нийслэлийн төсвөөс 68,2 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэн, худалдан авах ажиллагаа хийгдсэн. “Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хорооноос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл”-ийг хүлээн авах ажлын хэсгийн тушаалыг гарган тоног төхөөрөмжийг 2020 оны 9 дүгээр сарын 7 өдөр хүлээн авсан. Эдгээр тоног төхөөрөмжийг онлайн сүлжээнд холбогдсон алслагдсан хороодод хувиарлаж өгөхөөр төлөвлөж, улсын бүртгэлийн програмын тохируулга хийх ажил явагдаж байна.

Зураг 1.Тоног төхөөрөмж хүлээн авсан зураг



Хууль, дүрэм, журмын төсөлд санал өгөх талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн дараах хууль, дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллав. Үүнд:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Улсын бүртгэлийн байгууллагын тамга, тэмдэг хэрэглэх журмын төсөл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажлын төлөвлөгөө, журамд, Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журмын төсөл, “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөлд, “Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны явцад хяналт тавих журам”-д, Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмын төсөл, Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмын төсөл, Нэг-хот, нэг стандарт зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, бүртгэлийн байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Нийслэлийн 2021 оны нийгэм, эдийн засгийн зорилт, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төсөл, Бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгуулах санал, UB ERP системийн нэмэлт сайжруулалтанд саналыг тус тус гарган холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

1.2 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХЯЛБАРШУУЛЖ, ТҮРГЭН ШУУРХАЙ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах, иргэдийн төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргаар ахлуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/1289 тоот тушаалаар баталсан. Уг ажлын хүрээнд үйлчилгээний цонхны зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх, иргэний улсын бүртгэгчдийн ачааллыг бууруулах ажлыг судлан зохион байгуулах, хороодын үйлчилгээний менежментийг сайжруулах, баталгаажилтын процессыг өөрчлөх санал бэлтгэн ажлын хэсгийг хуралдуулан, санал боловсруулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажилласан. Уг ажлын хүрээнд холбогдох саналуудыг чиглэл бүрээр гарган хариуцсан газруудад саналуудыг танилцуулан ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр үзүүлэх нөхцлийг бүрдүүлсний үндсэн дээр шинээр байгуулагдсан Баянхошуу, Баянгол /E-Mart/ нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт 1, Хан-Уул дүүрэгт-5, Сонгинохайрхан дүүрэгт 11 хороо, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 тоот тогтоолоор Баянгол дүүрэгт 2 хороог шинээр байгуулахаар шийдвэрлэсэн. Уг хороодод ажиллах улсын бүртгэгч нарын цалин хөлсийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар шийдвэрлүүлэн ажилласан.

Төрийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд шуурхай үзүүлж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүдээр үзүүлж эхлээд байна. Мөн 2020 оны 10 дугаар 09-ний өдрөөс иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр олгодог хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдээр олгож эхлээд байна. Тайлант хугацаанд нийт 4269 бүртгэлийн үйлчилгээг үзүүлээд байна.

2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн УБЕГ-ын УБНА-ын газраас олгож байсан лавлагааг тухайн газраас олгохыг зогсоож, нийслэл дэх бүртгэлийн бүх нэгжүүдээс олгодог болсон.

Тус газар нь төрийн үйлчилгээнд гэрэгэ киоск, гэрэгэ пос машин, И-Баримт апплекэйшнаар дамжуулан үйлчилгээний төлбөр тооцоог авч байгаа бөгөөд 2020 оны 11 дүгээр сард дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад “Гэрэгэ системс” ХХК-ийн танилцуулга, бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн ашиглах заавар, зааварчилгаа, мэдээ, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. 2020 оны 11 сарын байдлаар Гэрэгэ киоск- 74000 иргэн, Төрийн төлбөр тооцооны И-баримт аппликейшнээр 34125, нийт 108125 иргэн үйлчилгээ авсан. Хотоос алслагдмал дүүргүүд буюу Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс, Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд гэрэгэ киоск, Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст гэрэгэ посыг 2020 оны 11 дүгээр сард суурилуулан ажиллалаа. Хотын засаглал сайжруулах төслийн хүрээнд төвийн 6 дүүргийн 24 хороонд мөн суурилуулан ажилласан.

1.3 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай хуралдаан, даргын зөвлөлийн хуралдаан, холбогдох ажлын хэсгүүдийн хуралдаанууд, мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаан, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухай бүр оролцож өгөгдсөн үүрэг даалгаварын хүрээнд Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын удирдах

албан хаагчдын шуурхай хуралдааныг 13 удааг зохион байгуулж, хурлаас нийт 160 үүрэг даалгавар өгснийг холбогдох хэлтсүүдэд тухай бүр хүргүүлэн биелэлтийг гарган ажилласан.

УБЕГ болон НЗДТГ бусад дээд газарт дараах тайлан, мэдээ, судалгааг хүргүүлж ажиллав.

Тус газар нь 2020 онд нийт 53 төрлийн тайлан, мэдээг давхардсан тоогоор 187 удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлт-2
2. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт -2
3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-2
4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2
5. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-2
6. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт-1
7. Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт-4
8. НИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийн тайлан-4
9. Байгууллагын хагас бүтэн, жилийн үйл ажиллагааны тайлан
10. Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт-2
11. НУБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан-1
12. НУБГ-ын Нийгмийн даатгалын тайлан-12
13. НУБГ-ын Хүн амын орлогын албан татварын тайлан -4
14. НУБГ-ын улсын тэмдэгтийн хураамжийн тайлан-2
15. НУБГ-ын Орлогын тайлан-2
16. Төсвийн гүйцэтгэл-12
17. Иргэний улсын бүртгэлийн сарын тоон мэдээ-12
18. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар-тухай бүр
19. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт, чиглэлийн хэрэгжилт-24
20. Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-тухай бүр
21. Нэгжийн ил тод байдлын үнэлгээний тайлан-2
22. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан-сар бүрийн 05-ны дотор
23. Нийслэлийн Засаг даргын албан даалгаварын хэрэгжилтийн тайлан- сар бүрийн 05-ны дотор
24. Удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан-2

25. Нийслэлд зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тухай мэдээ-1
26. Эрх зүйн ажлын тайлан-2
27. Нийслэлийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт-2
28. Гадаад харилцааны үйл ажиллагааны тайлан-2
29. Гадаад улс оронд албан томилолтоор ажилласан тухай тайлан- Ажлын 7 өдрийн дотор
30. Байгууллагуудын сарын үйл ажиллагааны тайлан, мэдээ-12 удаа
31. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх сэтгэл ханамжийн судалгааны тайлан-1 удаа
32. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2
33. Авлигын эсрэг үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2
34. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2
35. “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2
36. “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт-2
37. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт-2
38. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-2
39. Терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт-2
40. Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-2
41. НУБГ-ын сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэгжилт-2
42. Үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загвар /НЗД-ын 335 дугаар захирамж/-ын биелэлт-2
43. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт-2
44. Байгууллагын үйл ажиллагааг шалган зааварчилсан ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-2
45. Агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт-Улирал бүр
46. Агаарын бохирдлын эсрэг календарчилсан төлөвлөгөөний биелэлт –4 удаа
47. “Нэг-хот нэг стандарт” төлөвлөгөөний биелэлт -2 удаа
48. “Маскаа зүүцгээе гараа угаая” аяны хэрэгжилтийн тайлан-5 удаа
49. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт -2 удаа
50. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлогын хүрээнд архи согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах аяны хэрэгжилтийн тайлан-2 удаа
51. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээ-2

52. Сайжруулсан шахмал түлшний түгээлтэнд хяналт тавьсан тухай тайлан-7 хоног бүр /5 удаа/

53. НУБГ-ын 7 хоногийн ажлын мэдээ-7 хоног бүр /13 удаа/

Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын тушаал, шийдвэр, гэрээний төслийг боловсруулж, батлав.

Тус газраас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 33, хүний нөөцийн чиглэлээр 57, нийт 90 тушаалын төслийг хянаж, даргаар гарын үсэг зуруулж, нэгдсэн дугаар олгож албажуулан ажилласан байна. Уг тушаалын хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.

Мөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд 2 удаагийн чиглэл, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.

Бусад байгууллагатай хамтран ажиллав.

Тус газар нь 2020 онд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, дүүргүүдийн засаг даргын тамгын газар, нийгмийн халамжийн газар, нийгмийн даатгалын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, Бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, дүүргүүдийн прокурор болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн өөрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК “ Азийн хөгжлийн сан” “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан байна.

1.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын даргын тушаалаар баталсан журам, дүрэм, заавар, чиглэл, зөвлөмжийг мөрдлөг болгон албан хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2019 оны ХАСХОМ шинэчлэн гаргасан 313, шинээр томилогдсон 127, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 5 албан хаагч байна. Мэдүүлэхээс татгалзсан болон хуулийн хугацаанаас хожимдуулж мэдүүлсэн албан хаагч байхгүй.

Төрийн захиргааны нийт 417 албан хаагчаас нууцын баталгаа гаргуулан авсан. Мөн Монгол Улсын Их Хурлын сонгууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиар ажилласан нийт 1455 итгэмжлэгдсэн ажилтнаар нууцын баталгаа гаргуулан авсан.

Төрийн захиргааны 316 албан хаагчийн ажилласан жил болон зэрэг дэвийн судалгааг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Газрын албан хаагчдын ажлын үнэмлэхийг шинээр хэвлэх, болон сунгах ажлыг хийж дуусгасан.

“Хүний нөөцийн удирдлага, хяналтын нэгдсэн систем”-д төрийн захиргааны бүх албан хаагчийн мэдээллийг шинэчлэн бүртгэж, баталгаажуулсан.

Газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, ангилалыг нэмэх асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал хүргүүлсний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.20-ны өдрийн Б/155 тушаалаар тус газрын 117 төрийн захиргааны албан хаагчид шинээр, 147 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олгосон. Нийт 264 албан хаагчийн зэрэг дэв өөрчлөгдсөн нь нийт төрийн захиргааны албан хаагчдын 78.3 хувь юм. Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй болон албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаагаас бусад бүх албан хаагчид хамрагдсан байна. 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр болон ахиулан олгосон зэрэг дэвийн нэмэгдлийг олгож эхэлсэн.

Төрийн дээд шагнал, салбарын шагналаар шагнагдах албан хаагчдын анкет, ажил байдлын тодорхойлолт, өмнө шагнуулсан шагналын хуулбар зэргийг хүлээн авч холбогдох газруудад хүргүүлсний үр дүнд 92 албан хаагч шагнагдсан байна. Энэ нь нийт албан хаагчдын 23,29%-г эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу газрын даргын тушаалаар төрийн үйлчилгээний 25 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр, төрийн захиргааны 60 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоож олгосон.

Тус газар нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/07 дугаар тушаалаар 369 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсан бөгөөд 2020 оны Б/295 дугаар тушаалаар 410 албан хаагчтай байхаар батлагдсан. Төрийн үйлчилгээний 8, төрийн захиргааны 33 албан хаагчийн орон тоо шинээр нэмэгдсэн байна. Бичиг хэргийн эрхлэгч, архивчийн ажил үүргийг гэрээгээр гүйцэтгэж байсан албан хаагчдыг шинээр бий болсон орон тоонд жинхлэн томилж, нийгмийн баталгааг сайжруулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.06.19-ний өдрийн Б/295 дугаар тушаалын дагуу шинээр бий болгосон төрийн үйлчилгээний 8 албан хаагчийн ангилал зэрэглэлийг ТҮ-7-гоор тогтоосон. ТҮ-6, ТҮ-5 ангилалаар цалинжиж байсан 19 албан хаагчийн ангилал зэрэглэлийг ТҮ-7 болгон нэмэгдүүлсэн.

2020.06.19-ний өдрийг хүртэл тус газрын даргын 2013.10.16-ны өдрийн А/28 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийг сар бүр 20 хүртэл хувиар олгож байсан бөгөөд 2020.06.19-ний өдрөөс эхлэн сар бүр 25 хүртэл хувиар ур чадварын нэмэгдэл олгож эхэлсэн. 2020 оны Б/26 дугаар тушаалаар албан хаагч 1 сард хамгийн багадаа 10 хувь, хамгийн ихдээ

25 хувиар ур чадварын нэмэгдлийг тухайн сарын ажлын гүйцэтгэлээс хамаарч авах боломжтой болсон. Нийт 40 төрийн үйлчилгээний албан хаагч хамрагдсан.

Төрийн үйлчилгээний 40 албан хаагчтай “Хөдөлмөрийн гэрээ”, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах үүрэг бүхий 21 гэрээт албан хаагчтай “Зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх гэрээ”-г байгуулж ажиллалаа.

Тус газрын удирдлага харилцагч Голомт банкны Цэцээ гүн салбарын удирдлагатай удаа дараа уулзалт ярилцлага хийсний дүнд тус газрын албан хаагчдын цалингийн зээлийн 1 сарын хүү 1.5-1.9 хувь байсныг 1 сарын 1.2 болгон бууруулсан.


Газрын 17, Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн 45, Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн 39, нийт 101 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулсан.

1.5. СУРГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г батлуулан, уг сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилтын хүрээнд 2020 онд нийт 55 удаагийн сургалтад давхардсан тоогоор 5233 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас-19 удаагийн сургалтаар-3130
- ❖ Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас-36 удаагийн сургалтаар-1527
- ❖ Бусад сургалтууд -576 хамрагдсан байна.

Тайлангийн хугацаанд зохион байгуулагдсан нийт сургалтыг улирлаар нэгтгэн харьцуулан харуулбал :



2. Сургалтад хамрагдсан нийт ажилтны тоо - 5233 давхардсан тоогоор

	УБЕГ	НУБГ	Бусад байгууллагуудаас
Нийт	1617	2852	764
4-р улирал	1254	538	420
3-р улирал	29	894	7
2-р улирал	208	1286	310
1-р улирал	126	134	27

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг зохион байгуулах хүрээнд

Иргэдийг мэдээ мэдээллээр хангах болон “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн хууль тогтоомж, улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” ажлын хүрээнд эрх зүйн цахим хөтөч /e-hutuch.mn/ цахим хуудаст иргэний улсын бүртгэлийн /13/, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /30/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн /31/ төрлийн үйлчилгээний талаарх мэдээллийг оруулсан байна. Уг цахим хуудас /e-hutuch.mn/-аас улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, бүрдүүлэх бүрдүүлбэрийн талаархи мэдээллийг орон зай, цаг хугацаанаас хамааралгүй авах боломж бүрдсэн.
2. Тус газрын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг эхний хагас жилд “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”, “Иргэний үнэмлэх бүртгэл” сэдвүүдээр Баянзүрх, Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд 2 удаагийн сургалт зохион байгуулж 25 харилцагч хамрагдсан бол сүүлийн хагас жилд:
 - ❖ Хан-Уул дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс дүүргийнхээ Ерөнхий боловсролын дунд сургуулийн Ахлах ангийн нийт 1453 сурагчид “Улсын бүртгэлийн хууль тогтоомж” болон “Хэрэглэгчийн эрхийн ерөнхий ойлголт, хууль тогтоомж” сэдвээр сургалт зохион байгуулсан байна. Мөн “Улсын Улсын бүртгэлийн багц хуулийг сурталчилах” арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 23-нд “АПУ” ХХК-ны нийт 125 албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан.
 - ❖ Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн 103 дугаар дунд сургууль, 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 119 дүгээр сургууль, Эрдмийн Оргил цогцолбор сургуулийн ахлах ангийн сурагчдад Иргэний улсын бүртгэлийн тухай хууль/Биеийн

давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний үнэмлэхийн бүртгэл, Дахин олголтын бүртгэл/, Зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулсан.Сургалтад **272** оюутан, сурагч хамрагдсан.

- ❖ Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 2020 оны 11 дүгээр 02-ны өдөр Нийслэлийн Оюуны Ундраа Цогцолбор 96 дугаар, Нийслэлийн тэргүүний 47 дугаар сургуулийн ахлах ангийн нийт 320 сурагчдад улсын бүртгэлийн үүсэл хөгжил, түүхэн замнал, иргэний үнэмлэхийн ач холбогдлын талаар танилцуулга сургалтыг зохион байгуулж нийт **320** сурагч хамрагдсан.
- ❖ Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 5 удаагийн сургалтаар **131** харилцагчид эрх зүйн сургалт зохион байгуулсан.
- ❖ Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсээс “Улсын бүртгэлийн хууль сурталчилах сарын аян”-ныг зохион байгуулж, аяны хүрээнд нийт **3847** иргэн хамрагдаж нийт 2000 гаруй гарын авлага боршур тараасан байна.
- ❖ Мөн хорооны хэсгийн ахлагч нар болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтнуудад 15 удаагийн арга хэмжээгээр нийт **753** харилцагчид Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл өгсөн байна
- ❖ Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдаж, сургалт, мэдээллийн цагийг танхимаар зохион байгуулах боломжгүй болсон тул “Дэлхийн Монголчуудын радио MGL FM88.3”-радиотай хамтран 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн “Мягмар” гараг бүр 14 цагаас “Өдрийн хөтөлбөр”-өөр Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг нийт 23 удаа хүргэсэн.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын хүрээнд 46 сургалт зохион байгуулж нийт 6926 иргэн хамрагдсан байна.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын “2020 онд зохион байгуулах Сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт 21 арга хэмжээнээс улс орны хэмжээнд цар тахал гарч хүндрэлтэй байдал үүссэнээс шалтгаалан дараах арга хэмжээнүүд тасарсан.

1. Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавхи бэхжүүлэх” хөтөлбөрт ажилтнуудыг хамруулах;
2. Хуульчийн эрхтэй албан хаагчдыг Хуульчийн үргэлжилсэн сургалтад хамруулах;
3. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтад ажилтнуудыг хамруулах;

Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөсөн “Ажлын байрны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа,эрүүл ажлын байр”, “Жендэрийн тэгш байдлын тухай ойлголт”, “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал” зэрэг сургалтуудын материал боловсруулан нэгжүүдэд хүргүүлэн хэлтэс, ННҮТ-үүд сургалтуудыг боломжит хэлбэрээр зохион байгуулж, илтгэх хуудсаар тайлагнасан байна.

2016-2019 онд зохион байгуулсан сургалт

	Зохион байгуулсан сургалт /дотоод/	Оролцсон сургалт /гадаад/	Иргэдэд зориулсан сургалт
■ 2016	60	29	0
■ 2017	84	23	0
■ 2018	53	42	56
■ 2019	61	62	80
■ 2020	55	0	46

Газрын хэмжээнд Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жил, Улсын бүртгэлийн ажилтны өдрийг тохиолдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газраас зарласан болзолт уралдааны хүрээнд сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор дотоод нөөц бололцоогоо ашиглан 40 хүний суудалтай “Сургалтын танхим”-тай боллоо.

Цаашид сургалт явуулах арга хэлбэрийг улам боловсронгуй болгох, ялангуяа цахим хэлбэрээр сургалт зохион байгуулах дэд бүтцийг сайжруулах, ажилтнуудыг боломжтой үедээ өөрийгөө боловсруулах, хөгжүүлэх боломж бүхий сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох, ажилтнуудыг ялангуяа шинэ ажилтнуудыг мэргэшүүлэх, аргачлал бүхий гарын авлага материалаар хангах зорилт тавин ажиллаж байна.

1.6 САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын 2019 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж УБЕГ-т хүргүүлсэн.
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тус тус хугацаанд нь хүргүүлсэн.
- ❖ Санхүүгийн тайлангийн аудитыг Их наяд аудит ХХК-аар хийлгэж ЗӨРЧИЛГҮЙ дүгнэлт авсан.
- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь хоцрогдолгүй оруулсан.
- ❖ УБЕГ-ын тайлан, мэдээ гаргах журмын дагуу сар бүр тайланг дараа сарын 2-ны дотор хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
- ❖ 2021 төсвийн саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв /5805.0/ хэтрээгүй,

төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт оруулж өр авлагагүй, төсөв нэмэгдүүлэх санал 2 удаа өгч цалин 180.0 сая, урсгал засвар 6,2 сая төгрөг нэмэгдсэн. НЗДТГ-т 2 удаа санал хүргүүлсний дагуу цалин 199.0, үндсэн хөрөнгө 60,9 сая төгрөг нэмэгдсэн байна.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлсэн.

2020 оны 11 сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

-	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2020 оны 11дугаар сарын байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	6,5 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	675,1 сая төгрөг
			Тэмдэгтийн хураамж	1,041 сая төгрөг
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	27,8 тэрбум төгрөг

Улс, орон нутгийн сонгуулийн санхүүжилтийг батлагдсан зардлын ангиллын дагуу зарцуулах ажлын хүрээнд

- ❖ Улсын их хурлын сонгуулийн 640.7 сая төгрөгийн зардлыг УБЕГ-ын даргын баталсан А/595 дугаар тушаалын дагуу зарцуулж тайлагнасан
- ❖ Орон нутгийн сонгуулийн 398.1 сая төгрөгийн зардлыг УБЕГ-ын даргын баталсан А/1304 дугаар тушаалын дагуу зарцуулж тайлагнасан
- ❖ Улс, орон нутгийн сонгуулийн тайланг гүйцэтгэлээр нийслэлийн аудитын газарт шалгуулж зөрчилгүй гарсан.
- ❖ Батлагдсан төсвийн хүрээнд сар улиралын хуваарь гарган ажилласан.
- ❖ Сар улиралын үйл ажиллагаатай холбоотой тоо мэдээг үнэ зөв гаргаж тайлагнасан Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж хэтрэлт гаргаагүй ажилласан бөгөөд зарим хэмнэлттэй зардлуудаас дутагдаж байгаа зардалд шилжүүлэн тухай бүрт нь арга хэмжээ авч ажилласан.
- ❖ Шинээр байгуулагдсан 19 хороо, 2 нэгдсэн үйлчилгээний төвийн улсын бүртгэгч нарын цалинтай холбоотой зардлын танилцуулга НЗДТГ –т явуулж шийдүүлсэн
- ❖ Нийслэлийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд санал хүргүүлсэний үр дүнд 60.9 сая төгрөгийн шинэчилсэн бүртгэлийн техник тоног төхөөрөмж хүлээн авсан.

Үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг үнэн зөв хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллаа.

Орлого /үндсэн хөрөнгө/

УБЕГ-аас	НЗДТГ-ын хөрөнгө оруулалт	Дүүргийн хөрөнгө оруулалт
10 нэр төрлийн 158 ширхэг 157.1 сая төгрөг үнэтэй 102.9 сая төгрөг элэгдэлтэй	7 нэр төрлийн 70 ширхэг 68.2 сая төгрөг	9 нэр төрлийн 22 ширхэг 39.4 сая төгрөг ЧДЗДТГ

Үндсэн хөрөнгийн орлого: Улсын бүртгэлийн ерөнхий газраас 10 нэр төрлийн 158 ширхэг 157,1 сая төгрөгийн үнэтэй 102,9 төгрөг элэгдэлтэй, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 70 ширхэг 68,2 сая төгрөгийн орлого, Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалтаар 9 нэр төрлийн 22 ширхэг 39,4 сая төгрөгийн орлого хүлээн авч данс бүртгэлд бүртгэн ажиллав.

Зарцуулалт, хуваарилсан /үндсэн хөрөнгө/

Акталж ашиглалтаас хассан	Дүүрэгт шилжүүлсэн	Нэгдсэн төвд шилжүүлсэн	Бусад дотоодод шилжүүлсэн
33 нэр төрлийн 268 ширхэг 230.9 сая төгрөг	18 нэр төрлийн 290 ширхэг 345,8 сая төгрөг	6 нэр төрлийн 13 ширхэг 12.4 сая төгрөг	10 нэр төрлийн 28 ширхэг 17.9 сая төгрөг

Орлого/ бараа материал/

УБЕГ-аас	Урсгал төсөв	Сонгуулийн санхүүжилт
68 нэр төрлийн 1464876 ширхэг 372.6 сая төгрөг	91 нэр төрлийн 132851 ширхэг 163.9 сая төгрөг	58 нэр төрлийн 58401 ширхэг 146.8 сая төгрөг

Зарцуулалт, хуваарилсан /бараа, материал/

Акталж ашиглалтаас хассан	Үйл ажиллагаанд	Сонгуулийн зардалд	Бусад дотоодод шилжүүлсэн
15 нэр төрлийн 11005 ширхэг 1.4 сая төгрөг	159 нэр төрлийн 1582496 ширхэг 463.3 сая төгрөг	58 нэр төрлийн 58401 ширхэг 146.8 сая төгрөг	10 нэр төрлийн 28 ширхэг 17.9 сая төгрөг

Ажилчин албан хаагчдын цалин хөлс, урамшуулалыг цаг хугацаанд нь бодож олгож цагийн бүртгэл бусад тооцоололд хяналт тавьж ажиллаа. Цалингийн тооцооллыг бүтцийн өөрчлөлт, өр авлагатай холбон тооцоо хийж 2 удаа хуваарьт өөрчлөлт оруулж нэмэгдүүлсэн.

Үзүүлэлт сая.төг	Батлагдсан төсөв	Нэмсэн	Нийт төсөв	Олгосон
Цалин хөлс	4083.4	155.5	4238.9	4498.7
НДШ	508.3	157.6	692.8	586.8
Шинэ 19 хороо		199.9	199.9	
Нийт	4591.7	513.0	5104.7	5085.5

Бусад ажлын чиглэлээр:

- ❖ Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг үнэн зөв тооцож гаргаж анхан шатны баримт материалыг нэг стандартанд оруулсан
- ❖ Иргэн, эд хөрөнгийн бүртгэлийн тайлангийн загварыг боловсронгуй ойлгомжтой болгосоноор нярав эд хариуцагч нарын ажлын ачааллыг бууруулсан.
- ❖ Төлбөр тооцооны өөрчлөлттэй холбогдуулан баримт хүлээн авах тусгай хүснэгтийг гарган тооцоо авдаг болсон
- ❖ Хуулийн этгээдийн бүртгэлийн тайлан мэдээний загвар боловсруулж УБЕГ-ын санхүү, дүүргийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт хүргүүлсэн.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн мэдээлэлийн сангаас улсын бүртгэгч бүр тайлан мэдээ гаргадаг болгох зорилгоор бүртгэлийн мэдээлэлийн санд оруулах өөрчлөлтөнд санал өгсөн.

1.7 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

1.7.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн компьютерийн санамжид оруулан ажиллалаа.

12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 1550 албан бичгийн төслийг албан хаагчдаас хүлээн авч, удирдлагаар батлуулан, хэвлэмэл хуудсанд буулгаж, нэгдсэн дугаар олгон, едос системд бүртгэсэн байна. Дээрх албан бичгээс 1550 албан бичиг едос системээр хүргэгдсэн байна.

2020 онд edoc системээр 5975, байгууллага дээр 3771, нийт 9746 албан бичиг хүлээн авч бүртгэж, удирдлагад танилцуулж, холбогдох албан хаагчдад шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан байна. Дээрх албан бичгийн 4652 нь хариутай албан бичиг байсан бөгөөд тус газрын албан бичиг шийдвэрлэлтийн дундаж **нь 7 хоног 4 цаг байна.**

Албан бичиг шийдвэрлэлтийн хувь 100 байна.

Мөн хугацаанд 4721 албан бичгийн шийдвэрлэлтэд edoc системээр хяналт хийсэн байна.

Албан хаагчдаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 33, хүний нөөцийн чиглэлээр 57, нийт 90 тушаалын төслийг хүлээн авч хэвлэмэл хуудсанд буулгаж, даргаар гарын үсэг зуруулж, нэгдсэн дугаар олгож албажуулсан байна.

Байгууллагын архивын чиглэлээр:

а/ 2019 онд хөтлөгдсөн байнга хадгалах 43, 70 жил хадгалах 26, түр хадгалах 478 ширхэг хадгаламжийн нэгжийг батлагдсан хуваарийн дагуу холбогдох хэлтэс, нэгжүүдээс хүлээн авч, архивт нөхөн бүрдүүлэлт хийлээ.

б/ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.

в/ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.

г/ 2020 оны удирдлагаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 39, хүний нөөцийн чиглэлээр гарсан 117 тушаалыг ERP програмын archive edoc системд нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.

а./ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.


б./Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.

2019 онд тус газрын даргаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 39, хүний нөөцийн чиглэлээр гарсан 117 тушаал, тус газарт ирсэн 8638, явуулсан 1570 албан бичиг болон бусад баримт материалаар хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.

Хэвлэмэл хуудсны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.

Дотоод хэлтсийн ажилтнуудын гадуур ажиллах ажилтны бүртгэлийн дэвтэрийг өдөр тутам хөтөлж байна.



Тус газрын 2018, 2019 онд ирсэн бичгийг бусад онуудтай харьцуулбал: 2016 оныхоос 88 хувиар өссөн, 2017 оныхоос 7,2 хувиар буурсан, 2018 оныхоос 10,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018, 2019 онд ирсэн хариутай бичгийг бусад онуудтай харьцуулбал: 2016 оныхоос 1,9 дахин өссөн, 2017 оныхоос 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018, 2019 онд явуулсан бичгийг бусад онуудтай харьцуулбал: 2016 оныхоос 8 дахин өссөн, 2017 оныхоос 16 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2020 онд бүх үзүүлэлт буурсан байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио тогтоож байгууллагын хэвийн үйл ажиллагаа 1-5 сар, 11-12 саруудад тасалдсантай холбоотой байна.

Тус газрын албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хоног 7 хоног 4 цаг байна. Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундаж хугацаатай харьцуулбал 2 хоногоор шуурхай шийдвэрлэсэн харьцангуй өндөр үзүүлэлт юм.


1.7.2 Өргөдөл гомдол шийдвэрлэлт:

Тус газар нь иргэн, хуулийн этгээдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус газарт иргэн, байгууллагаас нийт 274 өргөдөл ирсэн байх бөгөөд үүнээс гомдол-193, талархал-7, хүсэлт -74, буцаагдсан-3 тус тус байна. Шийдвэрлэгдээгүй өргөдөл гомдол байхгүй.


Нийт өргөдөл, гомдлыг агуулгаар авч үзвэл байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой гомдол-40 буюу 21 хувь, Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гомдол-52 буюу 27 хувь, Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой-39 буюу 20 хувь, Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гомдол-38 буюу 19 хувь, Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гомдол-13 буюу 7 хувь, үлдсэн 6 хувийг бусад асуудлаар гаргасан гомдол тус тус эзэлж байна .

Өргөдөл гомдлын агуулгын эзлэх хувийг графикаар харуулбал:




- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой гомдол – 40
- Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гомдол-52
- Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гомдол- 38
- Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой -39


Ирүүлсэн өргөдөл гомдлыг улиралаар нь харуулбал:




1.2 Санал хүсэлт

Тайлангийн хугацаан тус газрын ажил , үйлчилгээтэй холбоотой нийт 74 санал, хүсэлт харилцагчид ирүүлсэн байна.






Өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн суваг



Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан, хуулийн хүрээнд шийдвэрлэлтийн хүрээнд сайжруулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ERP.Ulaanbaatar.mn системд тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийг байгууллагын дотоод нэгжүүдэд шилжүүлэх хүсэлт хүргүүлэв. Энэ нь өргөдөл, гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх шат дамжлагыг бууруулах ач холбогдолтой байна.



2018, 2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол 2016 оныхоос 46,6 хувиар, 2017 оныхоос 32,7 хувиар, 2018 оныхоос 46,6 хувиар тогтмол буурсан үзүүлэлттэй байна. 2020 оныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13 өргөдөлөөр буурсан үзүүлэлттэй байна.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 12 цаг 36 минут байна. Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаандаа шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

1.8.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Мэдээллийн сан, программ хангамжийн үйл ажиллагаа.

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээг Нетком хк-аар дамжиж сард төвийн сүлжээний төлбөрт 125 мянган төгрөг, жилд 1 сая 500 мянган төгрөг төлдөг байсныг Нийслэлийн Мэдээлэл технологийн газрын хамтын ажиллагааны хүрээнд тус газрын сүлжээний сувгийг ашиглан улсын бүртгэлийн сүлжээг дамжуулан хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна. Мөн тухайн жилд шинээр хоёр нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв нээгдсэн бөгөөд тус төвүүдийн улсын бүртгэлийн сүлжээг оруулж компьютер тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд орууллаа.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Азийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 хороог жишиг хороо болгох ажлын хүрээнд нийслэлийн худалдан авах ажиллагаа газартай хамтран зарласан Иргэний шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмжийн худалдан авах хоёр удаагийн тендерийн үнэлгээний багт орж шалгарсан компаниас тоног төхөөрөмжийг хүлээн авч холбогдох дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хүлээлгэн өгсөн байна. Мөн иргэний шинэчилсэн бүртгэлийг авах програмыг нэвтрүүлэх хүсэлтийг албан тоотоор хоёр удаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газарт хүргүүлэн ажилласан байна.

Тоног төхөөрөмжийн, програм болон сүлжээний аюулгүй байдлыг тасалдуулахгүй ажиллах хүрээнд тоног төхөөрөмжийн засвар гэмтлийг тухай бүр оношлон шуурхай засварлаж бүртгэл хөтлөн ажиллаж байна

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын <https://erp.ulaanbaatar.mn/>- системээр хүнийн нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер гэм мэт маш өргөн боломтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан бүртгэл хийж байна.

1.9 БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал


Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, “Мэдээллийн цаг”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 411 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.

- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах мэргэжилтний мэдээллийг газрын цахим хуудсанд нээлттэй байршуулан, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын

нэгдсэн төлөвлөлтийн систем /ERP/-д цахим өргөдөл, гомдлын дэд системийг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, www.ub1200.mn цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас, газрын 7777-1890 болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг 12 эх сурвалжаар иргэд, байгууллагаас 274 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан.

- ❖ Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд 10 хорооноос иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг шилжүүлснээр нийслэлийн хэмжээнд 41 хорооноос уг үйлчилгээг үзүүлж эхлэснээр иргэдэд засаг захиргааны харьяалал харгалзахгүйгээр 12 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Ингэснээр:
 - Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг зөвхөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн 9 цэгээс авдаг байсан бол хороодод шилжүүлсэнээр нийт 50 цэгээс үзүүлж үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан.
 - Хороодоос үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээ нэр төрөл 20 хувиар нэмэгдсэн.
 - Техник тоног төхөөрөмжийг шинэчилснээр үйлчилгээ үзүүлэх хугацаа багассан.
 - Иргэдийн үйлчилгээ авах цаг хугацаа болон зардлыг хэмнэсэн.
- ❖ 2020 оноос Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс иргэдэд үзүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.
- ❖ ,Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш авах боломжийг бүрдүүлэх зорилгоор хороо бүр ойрын харааны шилийг байрлуулсан.



Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал: Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдад

сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл зэрэг хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.


Байгууллагын шилэн дансанд хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг сар бүрийн эхний 7 хоногийн дотор буюу тогтоосон хугацаанд оруулав.

Гурав. Төсөв санхүүгийн ил тод байдал: 2020 оны НУБГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, НУБГ-ын 2020 оны эхний хагас санхүүгийн тайланг тус тус байршуулав.

Шилэн дансанд 145 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан бөгөөд хуулийн хугацаанд оруулсан.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байдал:

Тус газрын мэдээ, мэдээллийн ил тод байдлыг иргэн олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас Грийн софт хязгаарлагдмал хувьцаат компанитай хамтран аймаг, нийслэл дэх улсын бүртгэлийн газар хэлтсүүдэд нэг стандартын хүрээнд нэг загвартай мэдээ мэдээллийн сайт хөгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд хуучин ажиллаж байсан мэдээллийг сайтын мэдээ мэдээллийг нэг бүртчлэн шинэ сайтанд оруулж тухай бүр мэдээллийг тогтмол шинэчлэж байна.



Хуучин

www.nubg.ub.gov.mn




Шинэ

www.niislel@burtgel.gov.mn

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын албан ёсны цахим сайт болон нэгжүүдийн нүүр номонд нийлбэр дүнгээр 320 удаа улсын бүртгэлийн хууль, тогтоомж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, Ковид-19-өөс хэрхэн сэргийлэх тухай зөвлөмж, зөвлөгөө, Улсын Их хурлын, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиудыг сурталчлах, мөн Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж

хөгжсөний 80 жилийн ойтой холбоотой мэдээ, мэдээлэл оруулсан байна.




- ❖ Улс орны хэмжээнд цар тахал гарч гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах зорилгоор цахим сайт болон нүүр номонд зочлох зочдын тоо эрс өсч эхний 3 улирлын байдлаар нийт 72903 зочин зочилж байсан бол 4-р улиралд одоогийн байдал /2020 оны 12-р сарын 01-ны өдрийн/-р 29365 харилцагч зочилж тайлангийн хугацаанд нийт 102268 зочин шаардлагатай мэдээлэлтэй танилцсан байна.



- ❖ Нийслэлийн хэмжээнд нийт 10 “ЛАВЛАХ УТАС-“аар иргэн, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой лавлах үйлчилгээг нийт 11288 иргэн авсан байна.
- ❖ Улс орны хэмжээнд цар тахал гарч Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, хөл хорио тогтоосоноос хойш 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 3316 иргэн дээрх утсуудаар мэдээлэл авсан байна. Нийлбэр дүнгээр 14604 иргэн утсаар мэдээлэл авсан байна.
- ❖ Дэлхийн Монгол MGL FM 88.3 радиотой гэрээ байгуулан 23 удаа радиогийн шууд нэвтрүүлэгт оролцож бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгч ажилласан.
- ❖ Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилгын хүрээнд нийт иргэдэд эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэхэд зориулж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон лавлагаа олголтын бүрдүүлбэр, анхаарах асуудал, зөвлөгөө, байршил зэрэг мэдээллийг бэлтгэж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвд хүргүүлж, улмаар тус төвийн эрхлэн

хөтөлдөг “эрх зүйн цахим хөтөч” цахим сангийн мэдээлэл түгээж ажилласан.

<p>Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” ажлын хүрээнд эрх зүйн цахим хөтөч /e-hutuch.mn/ цахим хуудаст иргэний улсын бүртгэлийн /13/, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /30/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн /31/ төрлийн үйлчилгээний талаарх мэдээллийг оруулсан байна.</p>	
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------

- ❖ Хан-Уул, Чингэлтэй, Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс тус тус 1 удаа “НЭЭЛТТЭЙ ХААЛГА” арга хэмжээ зохион байгуулж нийт 4647 харилцагч хамрагдсан байна.
- ❖ Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс явуулын нэг цэгийн үйлчилгээг 2020 оны 09 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд 14,5,6,7,8,9,10,12,13,14,16,21 дүгээр хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан. Нийт 70 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж 270 гаруй иргэдэд заавар зөвлөгөө өгч ажилласан.Төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэснээр иргэдийн цаг хугацааг хэмнээд зогсохгүй төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны талаар үнэн зөв бодитой мэдээлэл хүргэгдэж, иргэдийн сэтгэл ханамж өндөр байсан.
- ❖ 2020 онд нийт 167 хосын гэрлэсний бүртгэлийг ёслолтой хийж, уг арга хэмжээнд нийт 529 харилцагч оролцсон байна
- ❖ Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 1/10289 тоот чиглэлийн дагуу төрийн бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг үндэслэн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг цахимаар болон хялбаршуулсан байдлаар үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, үйлчилгээ үзүүлэхдээ тухайн нэгж тогтсон утас, цахим шуудангийн хаяг ашиглах, цаг тогтоох, хүсэлт, холбогдох нотлох баримтын хуулбарыг цахимаар урьдчилан хүлээн авах, нягтлан шалгах, бүртгэлийг хөнгөвчлөх, хөл хорио тогтоосон цагийг харгалзах зэрэгт анхаарч дотоод үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа талаар хэлтсийн дарга Т.Булгантамир Монгол телевизэд ярилцлага өгч мэдээлэл хийсэн.




Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгсөн “Харилцагчдын үнэлгээ”-ний систем нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд Улсын бүртгэлийн үйлчилгээ авч буй харилцагчдаас “ҮНЭЛГЭЭ” авах ажлыг зохион байгуулж ажиллав. Тайлангийн хугацаанд “ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ” нэвтрүүлэх чиглэлээр нэлээдгүй судалгаа хийж, “Харилцагчаас үнэлгээ” авах програм ба техник хангамж нэвтрүүлэх төсөл”-ийн танилцуулга боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөс зарласан “Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд инновацийг нэвтрүүлэх нь” болзолт уралдаан болон Олон улсын хамтын ажиллагааны “Койка” байгууллагуудад хүргүүлсэн болно. Мөн УБЕГ-ын даргын зөвлөлд уг асуудлыг танилцуулсан.

Тайлангийн хугацаанд нийслэлийн улсын бүртгэлийн байгууллагын нэгжүүд сар бүр НУБГ_ХҮХ-3 маягтаар харилцагчийн үнэлгээ ирүүлж хэвшсэн бөгөөд Тайлант жилд нийт 4366 харилцагчаас цаасан хэлбэрээр “ҮНЭЛГЭЭ” авсан байх бөгөөд тус байгууллагаас авсан үйлчилгээний үнэлгээг дундажлан үзэхэд 95.3 хувийн чанартай үйлчилгээ авлаа гэж дүгнэсэн байна.

Нийт үнэлгээ өгсөн харилцагчдын 4165 нь уг үйлчилгээг “ХАНГАЛТТАЙ”, “МАШ САЙН” гэж үнэлсэн бол 201 харилцагч авсан үйлчилгээндээ сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн байна.



ХОЁР.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



2.1.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр 30-ны байдлаар **513919** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл-32415
- ❖ Гэрлэлтийн бүртгэл-5355
- ❖ Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-1675
- ❖ Үрчлэлтийн бүртгэл-468

- ❖ Овог эцэг /эх/-ийн нэр,нэр өөрчлөлтийн бүртгэл-1492
- ❖ Эцэг тогтоолтын бүртгэл-1018
- ❖ Нас баралтын бүртгэл-7098
- ❖ Засвар өөрчлөлт-236
- ❖ Гэрлэлт сэргээсний бүртгэл-26
- ❖ Төрсний гэрчилгээ дахин олголт-9571
- ❖ Гэрлэсний гэрчилгээ дахин олголт-534
- ❖ Нас барсны гэрчилгээ дахин олголт-1
- ❖ Аймаг нийслэлийн дотор шилжин суурьших бүртгэл-46777
- ❖ Аймаг нийслэлд шилжин суурьших бүртгэл-25583
- ❖ 16 нас хүрээгүй хүүхэд /шилжилт хөдөлгөөн/ -39024
- ❖ Иргэний үнэмлэх олголт /шинэ/-15578
- ❖ Иргэний үнэмлэх олголт /хугацаа сунгалт/-36155/
- ❖ Иргэний үнэмлэх олголт /дахин/-49553
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-65048
- ❖ Лавлагаа олголт-176312

Иргэний бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээ 2019 оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэлийн олголт 4 дахин буурсан буюу эрс багассантай холбоотой. Мөн сонгуультай холбоотойгоор шилжилт хөдөлгөөний бүртгэлийн үйлчилгээний тоо багассан байна.



Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

- ✓ ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газрын 12 иргэн
- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 417 дугаар нээлттэй хорих ангид хоригдож буй 17 хоригдолыг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамруулан ажилласан.
- ✓ Зорилтод бүлгийн 7 иргэнийг Дэлхийн зөн ОУБ-тай хамтран бичиг баримтжуулсан
- ✓ Гэр бүл, хүүхэд, залуучдын хөгжлийн хэлтсийн “Хүүхэд хамгаалал” 4 дүгээр улирлын нэгдсэн арга хэмжээний үеэр илэрсэн зорилтод бүлгийн 6 хүүхдэд төрсний гэрчилгээ, Огт бичиг баримтгүй 2 хүүхдийн төрсний гэрчилгээг, “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд 12 иргэнд иргэний үнэмлэх олгож бичиг баримтжуулан хамтран ажилласан.
- ✓ 401 дүгээр хаалттай хорих ангид ял эдэлж буй иргэний шинэчилсэн бүртгэлийг Хорих ангийн нэгдсэн эмнэлэгт очиж гар хурууний хээ, зургийг авч шинэчилсэн бүртгэлийг авч бичиг баримтжуулсан.
- ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 187 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/39 дүгээр захирамжийн хүрээнд: “Гэртээ харих зам” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллганы төлөвлөгөөний Иргэдийг бичиг баримтжуулах ажилд хамтран ажиллах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд өрх толгойлон амьдардаг зорилтот бүлгийн 6 хүүхэдтэй иргэнд бичиг баримтгүй болсон тул Хан-Уул дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэр гарсан тухай актыг үндэслэн доорхи иргэдийг торгуулиас чөлөөлөн бичиг баримтжуулав.
- ✓ Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд амьдардаг Зорилтот бүлгийн 1 иргэнийг Хорооны засаг даргатай, 14 дүгээр хорооны 1 иргэнийг “Өсөх өлзийт” хадгаламж зээлийн хоршоотой тус тус хамтран бичиг баримтжуулав.
- ✓ Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь Баянзүрх дүүргийн ЗДТГазрын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй болон амьжиргааны төвшин доогуур иргэдийн судалгаанд хамрагдсан 217 иргэний цахим иргэний үнэмлэхийг, Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучдын хэлтэстэй хамтран 4 хүүхдийн төрсний гэрчилгээг, 1 иргэний үнэмлэхийг; Баянзүрх дүүрэгт байрлах ШШГЕГазрын харъяа нээлттэй, хаалттай 407,409,421,441 дүгээр хорих ангиудад хоригдож байгаа 164

хоригдлын иргэний үнэмлэхийг; Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд 5 иргэнд иргэний үнэмлэхийг; Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас “Бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсний 80 жилийн ой”-г угтсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Баянзүрх дүүргийн харьяат зорилтот бүлгийн 50 иргэний цахим үнэмлэхийг нийт 441 иргэнийг бичиг баримтжуулсан байна.

- ✓ Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/231, 6 дугаар сарын 15-ний өдрийн А/283 тоот захирамжаар Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор иргэдийг бичиг баримтжуулах аяныг зохион байгуулахаар болсон. Уг ажлын хүрээнд 2430 иргэнд иргэний үнэмлэх үнэ төлбөргүй олгох ажлыг зохион байгуулж, тус хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар Дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн иргэдийн нэрсийг жагсаалтаар авч, бүртгэлийг хөтөлж, иргэдэд иргэний үнэмлэхийг олгох ажлыг хийж гүйцэтгэсэн. **Тайлангийн хугацаанд нийт 2928 иргэний бичиг баримтжуулан ажиллалаа.**

2.2 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн тоон мэдээ 2020 оны 11 дүгээр 30-ны байдлаар /өссөн дүнгээр/ **213577** мэдүүлэг хүлээн авч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-26304
- ❖ Өмчлөх эрх шилжих гэрээ-36243
- ❖ Барьцааны гэрээ-124041
- ❖ Бусад гэрээ-1021
- ❖ Бүртгэлд өөрчлөлт оруулах-8252
- ❖ Лавлагаа, хуулбар-15985
- ❖ Урьдчилсан тэмдэглэл-1084
- ❖ Хувийн хэрэг хаах-639
- ❖ Эрх бүхий этгээдийн шийдвэрээр бүртгэл хүчингүй болгох




Эд хөрөнгийн улсын бүртгэлийн 2018, 2019 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь

2016 оны бүртгэлээс 5 хувиар буурсан, 2017 оны бүртгэлээс 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд 2019 оныхоос өссөн үзүүлэлттэй байна.

2.3 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2020 оны 8 дугаар сараас эхлэн авч эхэлсэн бөгөөд 2020 оны 11 дүгээр 30-ны байдлаар нийт 4269 бүртгэл хийгдсэн байна.. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл – 847
- ❖ Дахин авсан – 101
- ❖ Нэр олгох-487
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах– 2524
- ❖ Хуулийн этгээдийн үйлчилгээ явуулах эрхийг сунгах-9
- ❖ Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бусад бүртгэл-18
- ❖ Лавлагаа-283



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2018, 2019 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2016 оны бүртгэлээс 1,3 хувиар, 2017 оны бүртгэлээс дунджаар 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2020 онд бусад оныхоос 33 дахин өссөн байна. Энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2020 оноос нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдээс үзүүлдэг болсонтой холбоотой. Энэ нь үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах томоохон ажил болсон юм.

Дээрх 3 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөр 2020 оны 11 сарын байдлаар Нийслэлийн хэмжээнд нийт 731765 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Тус газрын 2018, 2019 онд иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2016 оныхоос дунджаар 30 хувиар, 2017 оныхоос 20 хувиар тус тус өссөн, үзүүлэлттэй байна. 2020 онд бүртгэлийн үйлчилгээний тоо буурсан нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэлийн үйлчилгээний эрс багассантай холбоотой.

2.4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Архивын хэлтэс нь Төрөөс архивын үйл ажиллагааны талаар явуулж буй бодлого чиглэлийг нийслэлийн бүртгэлийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг архивт хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах, журмын дагуу хадгалж хамгаалах, ашиглуулах, лавлагаа мэдээлэл, хуулбар олгох, данс, тоо бүртгэл хөтлөх, архивын ажлын хяналт шалгалт, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдийн архивын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

- ❖ **Нөхөн бүрдүүлэлтийн чиглэлээр:** Нийт **134227** баримт иргэний баримтын архивт хүлээн авсан. Үүнээс 9 дүүргийн бүртгэлийн хэлтсээс **104824** баримт, орон нутгийн бүртгэлийн хэлтсээс **28512**, эх нотлох баримт **891** хадгаламжийн нэгж, баримт архивт хүлээн авч, нягтлан шалган, ангилан төрөлжүүлсэн.
- ❖ Сан хөмрөгт байрлуулах **153108** баримтыг он цаг, нэрийн дараалалд оруулан галиглан цэгцэлсэн.
- ❖ Галиглаж цэгцэлсэн **166914** баримтыг хадгаламжийн санд байрлуулсан байна.
- ❖ Баримт байрлуулах явцдаа **1311** баримтыг хувийн хэрэгжүүлсэн.
- ❖ Хадгалах хугацаа дууссан **6431** баримтыг хадгаламжийн нэгжээс түүвэрлэсэн.
- ❖ Баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүднээс **17714** баримтыг сэлбэн зассан.

Иргэний баримтын цахимжуулалтын сангаас олгосон лавлагааг үндэслэн мэдээллийн санд **610** бүртгэлийг нөхөн оруулахаар иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэний үндсэн дээр дээрх иргэдийн бүртгэлийн зөрчлийг арилгуулан ажилласан.

Архивын баримтын ашиглалт: Нийт **176312** лавлагаа, мэдээлэл олгосон байна.

Нөхөн бүртгэл, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэнд, лавлагаа мэдээлэл олгох зэрэгт **687** баримтыг архиваас шүүн, ашиглуулж, хуулбарлан хүргүүлж, буцаан байрлуулсан.


Иргэний хувийн хэргийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс нягтлан шалгах шаардлагатай **38377** баримтыг сүлжээнд шалгаж, холбогдох газарт хүргүүлэх, бусад сан хөмрөгт шилжүүлэн байрлуулах ажлуудыг хийсэн.

Бүртгэлийн зөрчлийн арилгахад **206** баримтыг хуулбарлан холбогдох ажилтан, иргэнд олгосон.

Сан хөмрөг №1, 3-т тоо бүртгэлийг шинэчлэн хөтлөх зорилгоор хадгаламжийн нэгжид тооллогыг өөрсдийн хүчээр 2020 оны 02 дугаар сарын 20-ноос эхлүүлэн нийт **5699** ХН, **534253** хувийн хэрэг, **759018** хуудас баримтыг тоолоод байна.

2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн УБЕГ-ын УБНА-ын газраас олгож байсан лавлагааг тухайн газраас олгохыг зогсоож, бүртгэлийн бүх нэгжүүдээс өгөх болсонтойгоор Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын удирдлагуудтай 2020.10.13, 22-ны өдрүүдэд уулзалт зохион байгуулж дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд лавлагаа олгох эрх, цахим мэдээллийн санд ажиллах эрх нээлгэх, ямар тохиолдолд УБНА-ын газарт иргэдийн асуудлыг шийдвэрлэх талаар харилцан санал солилцож, чиглэл боловсрууллаа.

Тус газраас 2020.10.13-ны өдөр Багахангай дах “Илч орд” уурын зууханд 2012-2016 онуудын сонгуулийн архивын баримтуудыг устгах ажиллагаанд хэлтсийн архивч нар оролцож, хэлтсийн дарга Н.Ганбаяр, гэрээт ажилтан Э.Цэрэндондов нар газар дээр нь устгалыг Багахангай дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч М.Уранцэцэгийн хяналтан дор бүрэн гүйцэд хийж гүйцэтгэсэн.



Хадгалах хугацаа дууссан баримтыг устгах тухай Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын 2020 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн А/19 дугаар тушаалаар архивын хадгалах хугацаа дууссан баримтыг устгах ажлын хэсгийн бүрэлдхүүн, устгах ажлын хуваарийг батлан, 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 21-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн нэгдсэн

архивын “Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс”-ын 2019 оны 01 дүгээр хурлын шийдвэрээр Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтын дагуу хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй иргэний үнэмлэх олгосон ИУБ-21 маягт 59958, шилжилт хөдөлгөөний ИУБ-22 маягт 62391 , ИГБББ-ийн лавлагааг үндэслэн гэрчилгээ олгосон тухай бүртгэлийн дэвтэр 200, ИУБ-ийн маягт архивт хүлээлгэн өгсөн тухай дагалдах хуудас 355, ИГБББ лавлагаа 48, архиваас түр олгох бүртгэлийн дэвтэр 99, захиалгын хуудас 4267 ширхэгийг тус тус зохих журмын дагуу устгасан.

2.5 Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт шалгалт 8, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 64, өргөдөл санал гомдлын мөрөөр 1072 шалгалт, гүйцэтгэлийн шалгалт 4, нийт **1148** шалгалт хийсэн байна.

2020 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 83562 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 14829 бүртгэлд, хуулийн этгээдийн чиглэлээр 265 бүртгэлд, архивын чиглэлээр 1701 нийт **100357** бүртгэлд байнгын хяналт тавьж, 2471 зөрчил илрүүлэн, хяналтын улсын байцаагчийн 2298 дүгнэлт гарч, 22528 иргэн, хуулийн этгээдэд нийтдээ 607210000 /зургаан зуун долоон сая хоёр зуун арван мянга/ төгрөгийн торгууль ногдуулсан байна.

МУ-ын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд тус газрын хяналтын улсын байцаагч нар хяналт тавьж ажилласан байна.

2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан хурлаар баримт бичиг барьцаалсан эсэхэд Нийслэлийн Прокурорын газар, Цагдаагийн удирдах газартай хамтран ажиллах чиглэл өгсөн. Чиглэлийн дагуу дүүргүүдийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүр, ТҮЦ, зочид буудлуудаар 2020 оны 04 дүгээр сарын 07-09-ны өдрүүдэд шалгалт хийж бичиг баримтыг хураан авч ажилласан.




Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн удирдамжын дагуу Нийслэлийн улсын бүртгэлийн газрын хяналтын улсын

ахлах байцаагч Г.Энхтулга Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн 32 хорооны улсын бүртгэгч нарын бүртгэл хөтлөлт, лавлагаа олголтонд хяналт шалгалтыг 2020 оны 3 дугаар сарын 3-аас 3 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд хийсэн. Уг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/1388 тоот тушаалаар Хяналт шалгалтын газраас “Улсын бүртгэлийн хэлтэс болон зарим хороодын үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэх, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах” шалгалтын баг Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг шалгаж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд: Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, өдөр тутмын хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ_СТ_1, НУБГ_СТ_2 маягтаар хэрэгжилтийг дүгнэж, тус хэлтэст ирүүлж хэвшлээ. Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдээс “ДҮГНЭХ ХУУДАС”-аар сар бүр ирүүлсэн үнэлгээг улирлаар нэгтгэн дундажлан харуулбал:



Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд нилээдгүй ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Тайлангийн хугацаанд нийт 3 удаа нэгжүүдэд чиглэл хүргүүлсэн байна.
2. Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 8 дугаар сарын 5-ны өдрөөс 14-ны өдрүүдэд дүүрэг дэх /Багахангайгаас бусад/ Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний 5 төв, мөн нийт 13 хорооны улсын бүртгэгчийн үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, харилцагчийн үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч “ТУСЛАН–ЗӨВЛӨХ”-өөр ажиллав. Туслан зөвлөх ажлын гүйцэтгэлийг “Илтгэх хуудас”-аар газрын даргад танилцуулж, нэгжийн удирдах албан тушаалтнууд, улсын бүртгэгч нарт 3 бүлэг 21 зүйл бүхий “ЗӨВЛӨМЖ-АРГАЧЛАЛ”-ыг хүргүүлэв.




3. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ын 10.2 дугаар заалтын дагуу тус хэлтсийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх ажлыг УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2020 оны 4 дүгээр сарын 24-ны өдрөөс 5 дугаар сарын 7-ны өдрүүдэд хийж, 6 дугаар сард тус газарт зөвлөмж ирүүлсэн. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу газрын даргын баталсан “Хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 14 –ний өдөр тус газарт хүргүүлэв.
4. Мөн УБЕГ-аас зохион байгуулсан “Шинээр томилогдсон “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтнуудад “Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд – та бидний оролцоо” сэдвээр – 26 ажилтанд, мөн Сонгинохайрхан -22, Багануур -15, Налайх-11, Хан-Уул – 28 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчид, мөн нийслэлийн Эд хөрөнгийн эрхийн 88 улсын бүртгэгч нийт 164 ажилтан албан хаагчид “Төрийн албаны ёс зүй ба үйлчилгээний стандарт” сэдвээр сургалт зохион байгуулав.
5. Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангахад шаардлагатай “стандарт”-д тусгагдсан зүйлсийн судалгаа, төсвийг боловсруулж УБЕГ-т хүргүүлэв.



6. Улс орны хэмжээнд цар тахал гарч гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын хөл хорио тогтоосон хүндрэлтэй үед иргэд харилцагчид утсаар “ЛАВЛАХ “ үйлчилгээ авахыг чухалчилж байгаа бөгөөд үйлчилгээ үзүүлэхдээ

”Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын 8 дугаар зүйлд заасан “ЛАВЛАХ” үйлчилгээний алхмуудыг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж, мөн утсаар лавлах үйлчилгээ өгөхөд шаардлагатай “САНАМЖ”-ийн хамт 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдэд хүргүүлэв.

7. Нийслэлийн хэмжээнд 2019 онд хийгдсэн улсын бүртгэлийн тоон үзүүлэлт, нэгж бүртгэгчид оногдох бүртгэлийн тоо, ачаалал зэрэг ДАТА–д дүн шинжилгээ хийж, газрын даргын зөвлөлд болон УБЕГ-ын удирдлагад танилцуулсан болно.



Стандартын хэрэгжилтийн үнэлгээ 2019 онтой харьцуулахад 5 хувиар өссөн харагдаж байгаа боловч удирдах албан тушаалтнуудын ”ХАРИЛЦАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-ний талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах, хэрэгжилтийн байдалд сар бүр дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санаачлагатай ажиллах, дүгнэх аргачлалыг боловсронгуй болгох, үнэн зөв дүгнэх зэрэг асуудлууд хангалтгүй байна. Мөн стандартыг хангахад шаардлагатай төсвийг байгууллагын төсөвт тусгайлан оруулж зориулалтын дагуу зарцуулах хэрэгцээ байна. Улсын хэмжээнд төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хувьд “БРЕНД БҮҮК”- тэй болж, гадагшаа харилцагчид өгч байгаа мэдээ, мэдээллийг “БРЕНД БҮҮК”- ийн дагуу ижил хэлбэрээр хүргэдэг тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

ГУРАВ.УИХ БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

3.1 Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар баталсан.

Дээрх ажлын хэсгийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 60 заалт бүхий төлөвлөгөө”-ний төслийг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд НУБГазар нь дүүрэг дэх УБХ-үүдээс санал авч нэгтгэн, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, танилцуулах, сонгогч шилжих журмын

төсөлд саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас 49 заалт бүхий төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажилласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай” А/126 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор тус газраас дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

Бүртгэсэн төлөвтэй шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тухай бүрт баталгаажуулсан эсэхийг сайтар нягтлан шалгасан.

Иргэний улсын ахлах бүртгэгч бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөн зогсоосон тухай” тэмдэглэгээг 1 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон нийт 357 бүртгэлийн дэвтрийг хүлээн авсан байна.

Хорооны улсын бүртгэгч нар 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 1 дүгээр сарын 31-ний хүртэл бүртгэл хөтөлсөн 34243 ш ИУБ-22 маягтыг жагсаалт үйлдэн, дагалдах хуудсын хамт хэлтсийн архивчид хүлээлгэн өгсөн байна.

Хорооны улсын бүртгэгч нараас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон нийт 357 ш бүртгэлийн дэвтэр, үлдэгдэл 14701 ш ИУБ-22 маягтыг тэмдэглэл үйлдэн лацдаж, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст хадгалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог ирүүлснийг тус газрын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/239 дугаартай албан бичгээр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Нийслэлийн Засаг дарга болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар тус тус хүргүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнийн 20-д заасны дагуу нийслэлийн хэмжээнд “Сонгуулийн 451 хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тухай” дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд хүлээн авч, эх хувийг Иргэний Улсын бүртгэлийн газарт албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Нийслэлийн хэмжээнд 451 хэсгийн сонгуулийн эрх бүхий иргэнд хэсгийг оноосон. Мөн сонгуулийн хэсэгт байнга оршин суух хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэдийг хорооны улсын бүртгэгч нар нягтлан шалгаж, хэсэг оноогдоогүй үлдсэн сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-т заасан “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс

25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ” гэж заасны дагуу нийслэлийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгч нар нь олгогдсон эрхийн дагуу цахим санд нэвтэрч, сонгогчдын нэрийн жагсаалтыг Мэдээлэл технологийн газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэсэг тус бүрээр 3 хувь хэвлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаанд дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтнаас бүрдсэн нийт 167 ажилтан албан хаагчийн бүрэлдэхүүнтэй баг хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн хэмжээнд 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр /election.gasr.mn/ цахим сангаас сонгуулийн 451 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэсэн бөгөөд үүнээс үндсэн сонгогч 896767, “Түр хасав” тэмдэглэгээтэй 95723 сонгогч бүртгэлтэй байсныг хэсэг тус бүрээр тэмдэглэл үйлдэж ажилласан.

Мөн хэвлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын бүртгэгч нар нүүрлэх, нуруулдах хавтасласны дараа сонгогчдын нэрийн жагсаалтын хуудасны дугаар болон тухайн хуудасны эхэлсэн болон дууссан дэс дугаарыг хуудас тус бүрээр нягтлан шалгаж, 3 хувь стандартын дагуу хэвлэгдсэн /нэрийн жагсаалт болон жагсаалтад байх тэмдэглэгээнүүд бүрэн гүйцэд тод хэвлэгдсэн/ эсэхийг хувь тус бүрээр тус тус нягтлан шалгаж, хяналт тавьж ажилласан бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх хугацаанд ямар нэгэн зөрчил гараагүй болно.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг тестлэх явцад стандарт хэмжээ алдагдснаас бичвэр нуруулдах хэсэгт орсон болон хуудас дугааргүй гарсан, СНЖ-д тэмдэглэгдсэн тэмдэглэгээнүүд огт гараагүй болон дутуу гарсан, цаас давхар татагдаж нэр 2 цаас дээр хуваагдаж гарсан зэрэг техникийн алдаанаас шалтгаалсан болон принтерийн хор бүдэг гарснаас шаардлага хангахгүй хэвлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтын хуудсыг хэсгийн болон хуудасны дугаараар бүртгэн тоолж, акт үйлдэн хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас хяналт тавьж оролцсон ажилтан нарын хяналт дор нийт 7560 хуудас цаасыг цаас хэрчигч машин ашиглан устгалд оруулсан байна.

Мөн Сонгуулийн хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалтыг нийслэлийн сонгуулийн 451 хэсэгт сонгогчдын нэрийн жагсаалтын 1 хувийг цаасан хэлбэрээр хүлээлцсэн бөгөөд үүнээс үндсэн сонгогч 896767, “Түр хасав” тэмдэглэгээтэй 95723 сонгогч бүртгэгдснийг хэсэг тус бүрээр сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх актад тэмдэглэл үйлдэж, 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хуульд заасны дагуу хүлээлгэн өгсөн байна.

1.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын талаар:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион

байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/594 дугаар тушаалаар баталсан.

Дээрх ажлын хэсгийн 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 73 заалт бүхий төлөвлөө”-ний төслийг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд НУБГазар нь дүүрэг дэх УБХ-үүдээс санал авч нэгтгэн, ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, танилцуулах, сонгогч шилжих журмын төсөлд саналыг Ажлын хэсэгт хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сонгуулийн хэсэг байгуулахдаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоонд үндэслэхээр заасан.

Тус газар нь 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 1/741 дугаар албан бичгээр бүртгэлийн цахим мэдээллийн сангаас тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 11.00 цагийн байдлаар гаргаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн.

Сонгуулийн хэсэг байгуулсан тухай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хууль тогтоомжид нийцүүлж, нэг хэсэгт байх сонгогчдын тоог нягтлан, сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэр буюу байр, гудамж бүрэн орсон эсэхийг сайтар нягтлан шалгаж тогтоолын эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт тус тус албан бичгээр хүргүүлж ажилласан. Мөн Тойрог, хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд оруулах албан хаагчдад эрх нээх албан бичгийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн байна.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ” гэж заасан. Иймд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай А/1168 дугаар тушаал, Иргэний Улсын Бүртгэлийн Газрын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 5/7130 чиглэл, Хяналт Шалгалтын Газрын 8/7215 дугаар чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

Сургалтаар сонгогчдын нэрийн жагсаалтанд орох нэмэлт өөрчлөлтийг тусгаж, сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэн баталгаажуулж, тоног төхөөрөмж, хэрэглэгчийн кодыг хүлээлцэж, сонгогчдын нэрийн жагсаалтын програмыг түгжиж, хэсгийн хороодод хүлээлгэн өгч, цагдаагийн хэлтсийн харуул хамгаалалтад хүлээлгэн өгч ажиллаа.

Уг ажлыг зохион байгуулах ажлын бүрэлдэхүүнд Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын албан хаагчид, дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч/, иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч, иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч, хорооны улсын бүртгэгч, гэрээт ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, нярав, бичиг хэргийн эрхлэгч нийт **247** албан хаагч орж ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, уг хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/1385 тоот тушаалаар баталсан “Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шуурхай баг ажиллуулах” тухай тушаал, “Удирдлагын шуурхай багийн ажлын удирдамж”-ийг тус тус чиглэл болгон ажиллалаа.

Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн шуурхай багтай хамтран бэлтгэл ажлыг хангаж, тоног төхөөрөмжийн холболтыг хийж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих, сонгуулийн санал авах өдөр ажиллах Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын шуурхай багийн бүрэлдэхүүн, уг албан хаагчдын ажил үүргийн хуваарийг батлаж, хуваарийн дагуу нийслэл дэх улсын бүртгэлийн газар болон дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд ажиллалаа.

2020 оны 10 дугаар сарын 15-нд техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлын ханган хуулийн хугацаанд санал хураалтыг нээж, нээлтийн тайланг хэсгийн хороодод хэвлэн олгосон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн санал авах өдрийн мэдээг тогтоосон хугацаанд буюу 11:30, 14:30, 18:30, 20:00 цагуудад Улсын бүртгэлийн ерөнхий газар болон сонгуулийн хэсгийн хороонд өгч ажилласан.

Дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүд нь сонгуулийн санал авах өдөр гомдол гаргасан иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд шалган тухай бүр тэмдэглэл хөтлөн хариу өгч, сонгуулийн санал авах өдрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажилласан.

Нийт хэсгийн хороодоос сервер компьютер, клиент компьютер, хэвлэх төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийг акт үйлдэн хүлээн авч лацдаж, нөөц техник, тоног, төхөөрөмжийн хамт хэлтсийн байранд зөөн байршуулан цагдаагийн алба хаагчийн хамгаалалтанд авсан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үйл ажиллагаа нийслэлийн хэмжээнд хэвийн явагдаж амжилттай дууслаа.

Нэмэлт санал хураалт зохион байгуулж ажилласан тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу орон нутгийн сонгуулийн санал хураалт 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр болж Налайх дүүргийн 26 дугаар тойргийн 26-1-1, 26-1-2 дугаар хэсэгт санал тэнцэж, нэмэлт санал хураалт явагдахаар болсон. Уг ажлын хүрээнд 2020 оны 10

дугаар сарын 22-ны өдөр итгэмжлэгдсэн ажилтны сургалтыг зохион байгуулсан. 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдөр нэмэлт санал хураалтыг амжилттай зохион байгуулан ажилласан.

Дүгнэлт: 2020 оны УИХ-ын болон Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэмэлт санал хураалтын бэлтгэл ажлыг хуулийн хугацаанд бүрэн гүйцэтгэж амжилттай зохион байгууллаа.

ДӨРӨВ. ХОРОО ХУВААГДАХТАЙ ХОЛБООТОЙГООР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт 1, Хан-Уул дүүрэгт-5, Сонгинохайрхан дүүрэгт 11 хороо, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 тоот тогтоолоор Баянгол дүүрэгт 2 хороог шинээр байгуулахаар шийдвэрлэсэн.

Тус шийдвэрийн дагуу Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Дүүргийн хороодын хилийн заагийг шинэчлэн батлах тухай” 35 дугаар, Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Шинэ болон хилийн цэсэд өөрчлөлт орсон хороодод гудамжны нэр, дугаар олгох тухай” А/69 дугаар, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 9-ний өдрийн “Зарим хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” 35 дугаар, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 8/28 дугаар тогтоол тус тус гарч нийслэлийн хэмжээнд 19 хороог шинээр байгуулсан.

Ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд нийслэлийн хэмжээнд шинээр зохион байгуулагдсан 19 хороонд байнга оршин суух хаягийн бүтгэлтэй 31561 иргэний хаягийн бүртгэлд өөрчлөлт орсон. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2691 гэрчилгээг сольж олгосон байна

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг нь 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга, Бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч нарыг хамруулсан хурлыг зохион байгуулж, ажлын хэсгийн даргаас шинээр хаяг нь өөрчлөгдсөн, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн иргэний үнэмлэх солих, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих, хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг хэрхэн хийх талаар бүртгэл тус бүрээр үүрэг чиглэлийг өгч ажилласан. Мөн ажлын хэсгээс ирүүлсэн чиглэлийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн ахлахуудад хүргүүлж, мэдээллийг нэг бүрчлэн өгч, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэдийн

иргэний үнэмлэх солих, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих, хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг бүртгэсэн тухай тоон мэдээ авах хүснэгтийг боловсруулж дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд хүргүүлээд байна. Нийслэлийн хэмжээнд нийт 31561 иргэнд иргэний үнэмлэхийг сольж олгосон байна

ТАВ.КОВИД ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Бүх нийтийн өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлсэн ажил

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.13-ны өдрийн “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/259 дүгээр тушаалын дагуу Газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 09.00-15.00 хүртэл, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/369 дүгээр захирамжийн дагуу 3 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 30-ны өдөр хүртэл 10.00-16.00 цаг хүртэл ажлын цагийг богиносгон, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/419 дүгээр тушаалын дагуу газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал 09.00-15.00 цагийн хооронд иргэн хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, албан хаагчид 9.00-17.00 цаг хүртэл ажилласан. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын ажлын цаг богиносгох захирамж гараагүйгээс шалтгаалан 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал энгийн цагийн хуваариар буюу 9.00-18.00 цаг хүртэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.04.30-ны өдрийн “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/554 дүгээр тушаалын дагуу газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 09.00-15.00 цагийн хооронд иргэн хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, албан хаагчид 9.00-17.00 цаг хүртэл ажилласан. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл, Дүнжингарав, Оргил, Драгон/ дэх Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын ажлын цаг богиносгох захирамж гараагүйгээс шалтгаалан 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал энгийн цагийн хуваариар буюу 9.00-18.00 цаг хүртэл ажиллаж иргэдэд үйлчилсэн.

Нийт албан хаагчид “Ажлын тусгай горимд шилжих үеийн удирдамж”-ыг өдөр мөн үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан болно.

“Онцгой эрхтэй хариуцлагатай зохицуулагч”-ийн үүргийг 2020 оны 1 дүгээр сарын 19-нөөс 20-ны өдрийн 09 цаг хүртэл 24 цагийн хугацаанд гүйцэтгэж, Нийслэлийн саг даргын Тамгын газрын байранд ажилласан.


Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан захирамжаар өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 24 цаг тутамд гаргаж Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв /ОНӨААТҮГ/-д хүргүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудад, ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэж 7 хоног

тутам Нийслэлийн Онцгой комисст танилцуулж байх чиг үүргийн хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сайжруулсан түлшний татан авалт, түгээлт, борлуултын мэдээг нэгтгэн гаргаж 7 хоног бүр тайлагнаж байна. Мөн тайлангийн хугацаанд 2 удаа нийслэлийн Онцгой комиссын жижүүрээр, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар дүүргийн Онцгой комиссын жижүүрээр сар бүр ажиллаж нийт газар хэлтсээс тайлангийн хугацаанд 72 удаа жижүүрийн ажлыг хийж гүйцэтгэн, нийслэл Онцгой комисст мэдээллэж ажилласан.

2020 оны 05 дугаар сарын 06-08-нд Улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр “Корона вирусын халдвар /КОВИД-19 /-т цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуульд Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс идэвхитэй оролцлоо.



Монгол Улсын түүхэнд анх удаа зохион байгуулагдсан Ковид19 цар тахалын халдварын үеийн хамтын ажиллагаа, хариу арга хэмжээ сэдэвт дадлага сургуулилтад тус хэлтсийн хамт олон идэвхитэй оролцож шуурхай штаб-д 1-19 дүгээр хорооны нийт байр, гудамж тоотын нэгдсэн судалгаа, тус дүүрэгт амьдарч байгаа 14 улсын 289 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргаж өгч, 3 удаагийн цагийн байдлаар ирсэн 198 иргэний мэдээллийг шүүж өгч ажилласан.




Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, бүх нийтийн хөл хорио тогтоосон үед ажилласан байдал Дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Үүнд:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай засгийн газрын 2020 оны 178, 181-р тогтоол, Улсын онцгой комиссын даргын 20 дугаар тушаал, Нийслэлийн засаг даргын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

- A/1242,1248 дугаар захирамж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны “Гамшгийн үеийн орон тооны бус шуурхай штаб байгуулах тухай” А/1455 дугаар тушаалыг үндэслэн Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны А/29 тоот “Хариуцлагатай жижүүрийн хуваарь шинэчлэн батлах тухай” тушаал, НУБГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны А/30 тоот “Гамшгийн үеийн орон тооны бус шуурхай штаб байгуулах тухай” тушаалыг гарган нийт албан хаагчдад танилцуулан тушаалын дагуу 2020 оны 12 дугаар сарын 11-нийг хүртэл Нийслэлийн онцгой комисс, Нийслэл дэх улсын бүртгэлийн газар, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд тогтмол жижүүр ажиллуулалаа.
2. 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр онц байдлын зэрэг буурах үед тус газраас дүүргүүдийн онцгой комисстэй тохиролцсоны үндсэн дээр нэн шаардлагатай иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажиллах албан хаагчдын хуваарийг батлан уг хуваарийн дагуу албан хаагчид ээлжийн дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн.
 3. Уг хугацаанд Улаанбаатар-Буян ХК-ны байранд үзүүлдэг улсын бүртгэлийн үйлчилгээ /нас барсны бүртгэл/-г зогсоохгүйгээр тасралтгүй явуулсан болно.
 4. Хөл хорионы үеэр E-Mongolia цахим системээр захиалсан үндэсний энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэхний судалгааг гарган улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, Монгол Шуудан ХК-тай хамтран иргэдэд үнэгүй хүргэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.
 5. Газрын албан хаагчдыг хуваарийн дагуу ажилуулж байгаа ба иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хөл хорионы онцгой дэглэмийн үед мэдээллийг түргэн шуурхай, аюулгүй хүргэх зорилгоор хэлтэс тус бүр зөвлөгөө мэдээлэл өгөх утас ажилуулан шаардлагатай мэдээллийг өгч байна.
 6. Хөл хорионы онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор УОК болон НОК-с гарч байгаа шийдвэр, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийг танилцуулах, үүрэг чиглэл өгөх зорилгоор газрын шуурхай хурлыг 5 удаа, хэлтсүүд албан хаагчидтайгаа 2-3 удаа цахим хурал зохион байгуулж шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажилласан.



7. Дэлхий нийтийг хамарсан коронавирус “КОВИД-19” цар тахал Монгол улсад голомтлон гарсан тул гамшигаас хамгаалах бэлэн байдлын хатуу хөл хорионы

дэглэм тогтоосон. 2020.11.12,16-ны өдрүүдийн НУБГазрын даргын тушаалаар хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Баярцэцэг, мэргэжилтэн Г.Энхтуяа, Б.Минжин нар НУБГ-т, Нийслэлийн онцгой байдлын шуурхай штабт хариуцлагатай жижүүрээр ээлжлэн, хэлтсийн дарга Н.Ганбаяр ерөнхий жижүүрээр ажиллаж байна.Энэ хугацаанд Нийслэлийн онцгой байдлын шуурхай штабт 198 иргэний хаяг байршил, иргэний үнэмлэхний, хууль хяналтын байгууллагад 1240 иргэний лавлагаа мэдээллийг тус тус хүргүүлсэн.

8. Эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсын ажлын байр, үйлчилгээний танхим, үйлчилгээ үзүүлж буй цонхонд байршуулах ажлын хүрээнд томуу, томуу төст өвчний тархалт, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, албан хаагчдад газрын цахим хуудас, хэлтэс нэгжийн үйлчилгээний зааланд байршуулан мэдээлэл хүргэхийн зэрэгцээ цахимаар үйлчилгээ авах зааврыг газрын цахим хуудсанд дахин байршуулан иргэдийг зарим төрлийн бүртгэлийн үйлчилгээг гэрээсээ авахыг уриалсан.
9. Албан хаагч болон үйлчлүүлэгчдийг гар халдваргүйжүүлэх нөхцлөөр хангах ажлын хүрээнд шаардагдах ариутгалын стирт, клорценпт, жавелион, гипохлорид натрийн уусмалаар халдваргүйжүүлэлтийг өдөрт 3 удаа хийж, гар ариутгагчийг 9 дүүрэг, газрын байранд байршуулан албан хаагчид, үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх болон иргэдийг ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх нөхцлөөр хангасан.
10. Ажлын байр, өрөө тасалгаанд агаар сэлгэлтийг тогмол хийж, эд зүйлсээ ариутгаж цэвэрлэх ажлын хүрээнд ажлын байр, өрөө тасалгаанд агаар сэлгэлтийг өрөө тасалгаанд тогтмол хийж, эд зүйлсээ ариутган цэвэрлэсэн.
11. Албан хаагч, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн байгууллага, онцгой комиссын шийдвэрийг биелүүлэх шаардлага, зөвлөмжийг тогтмол тавьж ажиллах үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг үйлчилгээний байранд хуваарийн дагуу ажиллуулах арга хэмжээ авах ажлын хүрээнд үйлчлүүлэхээр ирж буй иргэдэд амны хаалт зүүх шаардлага тавьж, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй болохыг анхааруулж, хэрэгжүүлж ажилласан. Үйлчилгээ үзүүлж буй нэгжүүд жижүүрийн хуваарь гарган ажиллуулсан.
12. Тухайн нэгжид халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд тухайн орон нутгийн онцгой комисст мэдэгдсэний үндсэн дээр өгсөн чиглэл, зааврын дагуу ажлын байрыг бүрэн эсвэл хэсэгчлэн хаах, үйлчилгээг зогсоох арга хэмжээг яаралтай авч, дээд шатны байгууллагад энэ тухай мэдэгдэх заалтын хүрээнд тухайн нэгжид халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний бэлтгэл ажлыг зааврын дагуу хангасан бөгөөд тайлант хугацаанд халдварт өвчний сэжиг илрээгүй.
13. Харъяа нэгж тасаг болон үйлчилгээний ажилтнууд ажлын байрны халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогмол хийж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хүрээнд үйлчилгээний ажилтнууд ажлын байрны халдваргүйжүүлэлт,

цэвэрлэгээг тогтмол хийж байна. Хяналтыг тухайн нэгжийн ахлах ажилтнууд тавьж байна.

14. Эрүүл мэндийн яам, Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэр, удирдамжийг биелүүлэх хүрээнд Улс, нийслэлийн онцгой комисс, Эрүүл мэндийн яамны /www.mohs.mn/ цахим хуудас, эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөмж, шийдвэрийг тухай бүр газрын цахим хуудсанд байршуулан иргэд, албан хаагчдыг мэдээллээр шуурхай ханган ажиллаж байна
15. Албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс биеийн халууныг өглөө, өдөр, орой гэсэн давтамжтай хэмжих, амны хаалт, ариутгалын материалаар тогтмол хангах ажлын хүрээнд Урьдчилан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтэд шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс гаргаж, Урьдчилан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтэд зориулан тус газрын халуун хэмжигч 9, санитол 1000, винт 50, спирт 48 литр, албан хаагчдад маск 30000, гар ариутгагч, нэг удаагийн малгай 1100, 2400 ширхэг нэг удаагийн бээлий, 200 хамгаалах хувцас хэрэглэл, агаар цэвэршүүлэгч уусмал -25 литр, шүршигч 10, нүүрний хаалт 250, хурууны хээ цэвэрлэгч 210-г тус тус бүрэн хангаж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

6.1 Бусад ажил

1. Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын комиссын бүрэлдэхүүнд тус газрын дарга болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид орж ажилласан.



2. 2020 онд Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүд Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс зэрэг байгууллагуудтай хамтран 16 нас хүрч иргэний үнэмлэх авч байгаа 629 иргэнд үнэмлэхийг олгох "МУ-ын иргэнийн андгай өргөх ёслол"-ыг зохион байгууллаа.




3. Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жил, Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 80 жилийн ойг угтан Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг сорих, харилцан хууль дүрэм журмын мэдлэгээ солилцох, өрсөлдөх, сайн туршлагаас суралцах зорилго бүхий "Ажил мэргэжлийн уралдаан"-ыг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Уг уралдаан нь Иргэний бүртгэлийн тухай хууль, дүрэм, журам, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, журам, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, дүрэм, журам болон Улсын бүртгэлийн хууль, журам, дүрмийн хэрэгжилт бодит байдлын нийцэл, кейсээр ажиллах гэсэн агуулгын хүрээнд явагдсан.



Улсын онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Коронавирус халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Маскаа зүүцгээе, гараа угаая" 2 дугаар аяныг зохион байгуулах тухай 04 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг ханган аяныг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажилласан.



Засгийн газрын Тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн Эрүүл мэндийн Үндэсний төв, Нийслэлийн Спортын хорооноос 2020.10.21-30-ны өдрүүдэд "ДЭЛХИЙН АЛХАЛТЫН ӨДӨР-2020" "Идэвхтэй алхалтын 10 хоног" аяныг зохион байгуулсны дагуу албан хаагчдыг өдөрт 10.000 алхалт хийж өөрсдийн эрүүл мэнддээ анхаарах, алхалтын ач холбогдол, давуу талыг мэдэрхийг уриалан ажилласан.




Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс хүүхдүүдэд цахим орчны зохистой хэрэглээний тухай сургалтыг хэлтсийн албан хаагчдын 12-18 насны хүүхдүүдэд зохион байгуулан ажилласан. Уг сургалтын үеэр хүүхдүүдэд улсын бүртгэлийн хэлтсийн ажлын орчин болон улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг "Нэг цонх"-ны үйлчилгээний онцлогийн талаар танилцуулж ажилласан.



Мөн хэлтсийн албан хаагчдын 5-11 насны хүүхдүүдээр "Эцэг, эхчүүд хүүхдийнхээ нүдээр" сэдэвт зургийн үзэсгэлэн гаргалаа.



Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран “Сүүдэр бүү тусга” хүүхдийн эрх хамгааллын нөлөөллийн аянд нэгдлээ.



Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 9 дүгээр сарын 30-ны өдөр албан хаагчдын 12-18 насны 6 хүүхдийг хамруулсан “Цахим орчны зөв зохистой хэрэглээ” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт дүүргийн ГБХЗХХ-ийн хүүхдийн эрхийн ажилтан илтгэл тавьж, хүүхдүүдтэй чөлөөт ярилцлага хийлээ.



6.2 Бүртгэлийн байгууллагын 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд:

“Олон улсын ахмадын баярын өдөр”, Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч, хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан 2020 оны 10 дугаар сарын 02-ны тус газраас гавъяаныхаа амралтанд гарсан ахмад настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга

хэмжээг зохион байгууллаа.



Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч, хөгжсөний 80 жилийн ой, Бүртгэлийн ажилтны өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын 4 төрлөөр/ сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар/ “Шилжин явах цом”-ын төлөөх тэмцээнийг Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын нийт албан хаагчдын дунд 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.



10.4 Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч, хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус газраас үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй “Улсын бүртгэлийн газрын нэрэмжит цэцэрлэгт-төгөл”-тэй болох гэрээ хийсний дагуу үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих арга хэмжээг 2020.10.17-ны өдөр зохион байгуулж Улсын бүртгэлийн ерөнхий газраас 50 албан хаагч, Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас 60 албан хаагч тус тус оролцож, 2 төрлийн буюу голт бор 50 ширхэг, чацарганы 50 ширхэг нийт 100 ширхэг гоёлын мод тарьсан.



Улсын бүртгэлийн байгууллагын 80 жилийн ойг утгаж багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс харилцагч байгууллагуудын дунд шатрын тэмцээний зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн байгууллагын 80 жилийн ойг утгаж багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн залуучуудын зөвлөлөөс албан хаагчдын дунд уулзалт зохион байгуулж, тэргүүний оюунлаг хүүхдээ дэмжин урамшууллаа



Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын санаачлагаар одоогийн байдлаар 6000000 төгрөгөөр хэлтсийн байрыг засварлах ажлыг хийж байна. Засварын ажлыг албан хаагчид өөрсдийн биеэр хийж гүйцэтгэсэн.



Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт тавьж, үр дүнд нь 1 өрөө гаргаж өгсөн ба цаашид үйлчилгээний стандартад нийцсэн танхим, үйлчилгээний цонхыг орчин үед нийцсэн байдлаар тохижуулах ажлын хамтран шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Сайн үйлсийн хүрээнд:

Хүүхдийн тэмүүлэл аянд Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид 3000 төгрөг хандивлалаа. Нийт 75000 төгрөг хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Засаг даргын А/268 тоот захирамж гарсаны дагуу 12 хүртлэх насны хүүхэдтэй албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг гаргаж ажилласан. "Сэтгэлийн тус багадаагүй сайн дурын аян"-д тус хэлтэс идэвхитэй оролцсон.



Бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ой, Бүртгэлийн ажилтны өдрийг угтан тус газраас “Цус сэлбэлт судлалын үндэсний төв”-тэй хамтран “ Нэг бүртгэгч 3 амь аварья” аян зохион байгуулна. Байгууллагын албан хаагчид цусаа бэлэглэнэ. “Цус сэлбэлт судлалын үндэсний төв”-тэй хамтран “Нэг бүртгэгч 3 амь аварья” аян зохион байгуулж 2020 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр цусаа хандивласан.

Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд байрлах “Эрдэнэ” хүүхэд асрах төвийн 22 хүүхдэд дүүргийн хүүхэд хөгжил гэр бүл төвтэй хамтарч хувцас, хүнсний зүйлс хандивласан.



Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нийгмийн хариуцлагынхаа хүрээнд сайн үйлсийн аяныг зохион байгуулж, өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтсийн алба хаагчдад улсын бүртгэгч нар 1 өдрийн цалингаараа маск, гар ариутгагч өгч дэмжлэг үзүүлсэн байна. Мөн Гүнтийн постод ажиллаж байгаа Цагдаагийн 2 дугаар хэлтсийн алба хаагчдад халуун аарц, өдрийн хоол өгч, сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн.



Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс Нийгмийн хариуцлагын хүрээнд болон өндөржүүлсэн бэлэн байдалд цаг наргүй ажиллаж байгаа Баянзүрх дүүргийн цагдаагийн албан хаагч, Хот тохижилт үйлчилгээний 100 ажилтанд өөрсдийн нөөц боломжоо ашиглан нэг удаагийн өдрийн хоол, халуун аарц өгөх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Багахангай дүүрэг дэх улсын бүртгэгч М.Ариунбаяр, Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч агсан Б.Отгонтуяа, Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Д.Гэрэлжин нарт байгууллагаас болон газрын нийт хамт олноороо хандивын аян өрнүүлж тусалсан.

Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс 2020.05.05-ны өдөр Нийгмийн хариуцлагын хүрээнд, COVID19 цар тахал дэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Цагдаагийн постонд ээлжинд гарч буй Онцгой, Цагдаа, Хүн эмнэлгийн албан хаагчдад халуун хоол, цайгаар үйлчиллээ.



ДОЛОО. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР:

1. Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагатай хуулийн хүрээнд ажлаа идэвхтэй уялдуулан хамтарч ажиллах;
2. Иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах;
3. Анхан шатны нэгжээс үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор иргэний шинэчилсэн бүртгэл, иргэний үнэмлэх дахин авах бүртгэлийг хороодод шилжүүлэх;
4. Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хорооноос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг шинэчлэх;

НАЙМ. САНАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1. Нийслэл дэх улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үзүүлдэг. 2020 оны эхний 11 сарын байдлаар 731765 иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байх ба улсын төсөвт 6,5 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 29,6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж нийт төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний 60 гаруй хувийг үзүүлсэн байна. Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь түрээсийн байранд, Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд харъяа дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хүн ам, барилга байгууламж жил бүр өсөн нэмэгдэхийн хирээр ажлын байр, архивын сан хөмрөгийн багтаамж хүрэлцэхгүй байдал үүсч байна. Архивын сан хөмрөгт нийслэлийн 1445000 гаруй иргэдийн хувийн хэрэг материал хадгалагдаж байгаа бөгөөд архивын сан хөмрөг багтаамжгүй болсон байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэлийн архив 10 нэгжид байршиж байгаа бөгөөд зориулалтын бус хонгилын давхар, автомашины гражид байгаа нь архивын баримт хадгалах орчны стандарт шаардлагыг хангаж чадахгүй, улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архив үрэгдэх, устах өндөр эрсдэлтэй байна.

Иймд тус газарт ажлын байрны асуудлыг шийдвэрлэж өгнө үү.

2. 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн хэмжээнд 1602 ширхэг компьютер принтер, канон, скайнер ашиглагдаж байснаас 2001-2008 оны 118 ширхэг 2011 оны 6 ширхэг техник хэрэгслийн актлуулсан. Одоо ашиглаж байгаа техник тоног төхөөрөмжөөс 2009-2011 оны 203 ширхэг, 2012-2016 оны 1021 ширхэг техник тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй гацаж унтрах, сүлжээ удаан унших зэрэг хүндрэл гарч засвар үйлчилгээ хийж байна. 2017-2020 оны 273 техник хэрэгсэл ашиглалтын шаардлага хангаж байгаа нь 17,2%-ийг эзлэж байна. “Бүртгэлийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн 80 хувь нь ашиглалтын хугацаа дууссан учраас бүртгэлийн үйл ажиллагаа доголдох, удаашрах нөхцөл

бүрдэж байна. Иймд бүртгэлийн үйл ажиллагаанд ашигладаг тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилж, сайжруулах арга хэмжээг авч өгнө үү.

3. 2020 онд бүртгэлийн програмууд ачаалал ихсэх үед гацах, удаашрах, ажиллахгүй болох зэрэг хүндрэлүүд их гарч байна. Иймд бүртгэлийн програмын шинэчлэлийг хийж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх нөхцлөөр хангаж өгнө үү.
4. Иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэхэд зайлшгүй хийгдэх шинэчлэл нь төрийн үйлчилгээг цахимжуулах, онлайн хэлбэрт шилжүүлэх явдал юм.Иймд онлайн болоогүй байгаа үйлчилгээнүүдийг үе шаттайгаар онлайн болгох

ХЯНАСАН:ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЙГАЛМААА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН:

Б.ЦЭДЭН

